БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2023/99/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: huanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: К.Еркегүл<br>Утас: 98420220 Цахим хаяг: Erkegulk@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .......... 3
Асуудлыг онцолсон хэсэг .......... **Error! Bookmark not defined.**
Аудитын гол асуудал .......... **Error! Bookmark not defined.**
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .......... 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .......... 14
4. АУДИТЫН ТАЙЛАН .......... 17
4.1 Ерөнхий зүйл .......... 17
4.2 Материаллаг байдал .......... 17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .......... 17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .......... 17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .......... 18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .......... 18
4.5.1 Завсрын аудитын талаар .......... 18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .......... 18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .......... **Error! Bookmark not defined.**
5.1 Төлбөрийн акт .......... 19
5.2 Албан шаардлага .......... 19
5.3 Зөвлөмж .......... 19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .......... 20

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2023.02.24 № 181
танай ______ -ны № ______ -т

УЛААНХУС СУМЫН
СОГООГ ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.МАНЧҮК ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

**Аудитын гол асуудал**

Хүүхдийн хоолны батлагдсан нормын мөрдөлтөд анхаарах шаардлагатай байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх болович үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **56592838.95** | **68815842.19** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 0.00 | 8179414.42 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 0.00 | 8179414.42 |
| **3121** | **Төгрөг** | 0.00 | 8179414.42 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0.00 | 8179414.42 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 56592838.95 | 60636427.77 |
| **351** | **Түүхий эд материал** | 373900.00 | 248600.00 |
| 35130 | Эм боох материал | 373900.00 | 248600.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 56218938.95 | 60387827.77 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 17000.00 | 232350.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 22689860.00 | 26344000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2671645.00 | 594395.00 |
| 35460 | Хүнсний материал | 6773690.95 | 9150339.77 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 24066743.00 | 24066743.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **636712333.25** | **614124686.94** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 636712333.25 | 614124686.94 |
| **392** | **Биет хөрөнгө** | 629107333.25 | 606579686.94 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 623855089.16 | 623855089.16 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -27741745.64 | -40625994.20 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 9000000.00 | 9000000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -9000000.00 | -9000000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 26903700.00 | 23513550.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -10278675.40 | -12823887.84 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 26628156.00 | 16891000.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -15485005.76 | -8442050.18 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 12334163.00 | 12986163.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -10668328.11 | -12334163.00 |
| 39217 | Ном | 3559980.00 | 3559980.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 7605000.00 | 7545000.00 |
| 39301 | Програм хангамж | 575000.00 | 575000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -350000.00 | -410000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 7380000.00 | 7380000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **693305172.20** | **682940529.13** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3707470.00** | **6373344.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 3707470.00 | 6373344.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **413** | **Өглөг** | 3707470.00 | 6373344.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 3707470.00 | 6373344.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 3707470.00 | 6373344.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **689597702.20** | **676567185.13** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 689597702.20 | 676567185.13 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 41723775.00 | 41723775.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 41723775.00 | 41723775.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 592666761.04 | 580743609.97 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 592666761.04 | 593774127.04 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | -13030517.07 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 55207166.16 | 54099800.16 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **693305172.20** | **682940529.13** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **331,181,940.00** | **465,265,000.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **449,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 449,000.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | - | 449,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 449,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **331,181,940.00** | **464,816,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 321,407,940.00 | 413,398,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 413,398,900.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 6,078,940.00 | - |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | - | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 315,329,000.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 205,000.00 | 103,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 205,000.00 | 103,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 9,569,000.00 | 51,313,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 9,569,000.00 | 51,313,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **371,199,241.64** | **478,295,517.07** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **371,199,241.64** | **478,295,517.07** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 370,932,122.18 | 478,295,426.07 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 258,346,606.54 | 333,759,676.08 |
| 210101 | Үндсэн цалин | 231,357,864.54 | 276,534,776.20 |
| 210102 | Нэмэгдэл | - | 50,860,844.88 |
| 210104 | Урамшуулал | 18,793,342.00 | 6,364,055.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 8,195,400.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35,339,500.00 | 40,167,100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,868,600.00 | 27,313,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,617,700.00 | 3,213,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,094,200.00 | 2,570,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 523,500.00 | 642,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,235,500.00 | 6,426,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 8,032,695.00 | 19,655,924.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,892,500.00 | 2,021,274.00 |
| 210302 | Түлш, халаалт | 6,140,195.00 | 17,634,650.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,066,511.50 | 3,673,860.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 986,510.00 | 1,689,750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 333,501.50 | 428,950.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 468,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,278,500.00 | 1,555,160.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 39,323,145.66 | 53,209,319.68 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 97,500.00 | 402,350.00 |
| 210502 | Хоол, хүнс | 37,615,245.66 | 52,806,969.68 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,610,400.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 405,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 405,000.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 279,000.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 279,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 446,100.00 | 766,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 196,100.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 766,100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24,693,563.48 | 27,063,446.31 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 2,374,900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 988,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 24,693,563.48 | 23,699,646.31 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 267,119.46 | 91.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 267,119.46 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 267,119.46 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 91.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 91.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(40,017,301.64)** | **(13,030,517.07)** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(40,017,301.64)** | **(13,030,517.07)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **325103000.00** | **464816000.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **325103000.00** | **464816000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 315329000.00 | 413398900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 413398900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 315329000.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 205000.00 | 103500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 205000.00 | 103500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 9569000.00 | 51313600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 9569000.00 | 51313600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **322367000.00** | **455524585.58** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **322367000.00** | **455524585.58** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **322099880.54** | **455524494.58** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 261515380.54 | 333759676.08 |
| 210101 | Үндсэн цалин | 234526638.54 | 276534776.20 |
| 210102 | Нэмэгдэл | | 50860844.88 |
| 210104 | Урамшуулал | 18793342.00 | 6364055.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 8195400.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35339500.00 | 40167100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24868600.00 | 27313800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2617700.00 | 3213300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2094200.00 | 2570700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 523500.00 | 642600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5235500.00 | 6426700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 9359000.00 | 14839400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1892500.00 | 2021274.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7466500.00 | 12818126.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2925000.00 | 103500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 279000.00 | 103500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 416300.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 468000.00 | |
| 210404 | Ном, хэвлэл | 62800.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 205000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1493900.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 11515600.00 | 55183618.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 255800.00 | |
| 210502 | Хоол, хүнс | 10806400.00 | 55183618.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 453400.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 210000.00 | 300000.00 |
| 210604 | Урсгал засвар | 210000.00 | 300000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 279000.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 279000.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 810100.00 | 766100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 560100.00 | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 766100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 146300.00 | 10405100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 7695100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 146300.00 | 2710000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **267119.46** | **91.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 0.00 | 0.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 267119.46 | 0.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 267119.46 | |

| | | | |
|---|---|---|---|
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 0.00 | 91.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 91.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **2736000.00** | **9291414.42** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **3285710.00** | **1112000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3285710.00** | **1112000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 3285710.00 | 1112000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3285710.00 | 1112000.00 |
| **2260** | **Гадаад эх үүсвэрээр** | 0.00 | 0.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-3285710.00** | **-1112000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | -549710.00 | 8179414.42 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 549710.00 | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 8179414.42 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **41,723,775.00** | **55,207,166.16** | **592,666,761.04** | **0.00** | 689,597,702.20 |
| D01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **41,723,775.00** | **55,207,166.16** | **592,666,761.04** | **0.00** | 689,597,702.20 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 1,107,366.00 | | 1,107,366.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **41,723,775.00** | **55,207,166.16** | **593,774,127.04** | **0.00** | 690,705,068.20 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | -1,107,366.00 | | | -1,107,366.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | -13,030,517.07 | | -13,030,517.07 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **41,723,775.00** | **54,099,800.16** | **580,743,609.97** | **0.00** | 676,567,185.13 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны** | | **Тайлант оны** | |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 324898000.00 | 325180590.54 | 464712500.00 | 456532994.58 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 324898000.00 | 325180590.54 | 464712500.00 | 456532994.58 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 324898000.00 | 325180590.54 | 464712500.00 | 456532994.58 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 261774000.00 | 261515380.54 | 337379300.00 | 333759676.08 |
| 210101 | Үндсэн цалин | 234783200.00 | 234526638.54 | 270393500.00 | 276534776.20 |
| 210102 | Нэмэгдэл | | | 60137000.00 | 50860844.88 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | | | |
| 210104 | Урамшуулал | 18795400.00 | 18793342.00 | 6848800.00 | 6364055.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 8195400.00 | 8195400.00 | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 35339500.00 | 35339500.00 | 40167100.00 | 40167100.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24868600.00 | 24868600.00 | 27313800.00 | 27313800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2617700.00 | 2617700.00 | 3213300.00 | 3213300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2094200.00 | 2094200.00 | 2570700.00 | 2570700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 523500.00 | 523500.00 | 642600.00 | 642600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5235500.00 | 5235500.00 | 6426700.00 | 6426700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 9359000.00 | 9359000.00 | 14839400.00 | 14839400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1892500.00 | 1892500.00 | 3959400.00 | 2021274.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7466500.00 | 7466500.00 | 10880000.00 | 12818126.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2720000.00 | 2720000.00 | 0.00 | 0.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 279000.00 | 279000.00 | | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 416300.00 | 416300.00 | | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 468000.00 | 468000.00 | | |
| 210404 | Ном, хэвлэл | 62800.00 | 62800.00 | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1493900.00 | 1493900.00 | | |
| **2105** | **Нормативт зардал** | 11515600.00 | 11515600.00 | 59017000.00 | 55183618.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 255800.00 | 255800.00 | | |
| 210502 | Хоол, хүнс | 10806400.00 | 10806400.00 | 59017000.00 | 55183618.50 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 453400.00 | 453400.00 | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 210000.00 | 210000.00 | 300000.00 | 300000.00 |
| 210604 | Урсгал засвар | 210000.00 | 210000.00 | 300000.00 | 300000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 279000.00 | 279000.00 | 0.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 279000.00 | 279000.00 | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2654600.00 | 2646100.00 | 814000.00 | 766100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2404600.00 | 2396100.00 | | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250000.00 | 250000.00 | | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | | 814000.00 | 766100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1046300.00 | 1596010.00 | 12195700.00 | 11517100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | | 9195700.00 | 8547100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1046300.00 | 1596010.00 | 3000000.00 | 2970000.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 324898000.00 | 324630880.54 | 464712500.00 | 464712709.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 315329000.00 | 315061880.54 | 413398900.00 | 413398900.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | | 413398900.00 | 413398900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 315329000.00 | 315061880.54 | | |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 9569000.00 | 9569000.00 | 51313600.00 | 51313509.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 9569000.00 | 9569000.00 | 51313600.00 | 51313509.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 26.00 | 30.00 | 38.00 | 38.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 13.00 | 13.00 | 19.00 | 19.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 12.00 | 14.00 | 14.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 2.00 | 4.00 | 4.00 | 4.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 125.00 | 125.00 | 175.00 | 175.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН** | 125.00 | 125.00 | 175.00 | 175.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | | | | |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 125.0 | 125.0 | 175.00 | 175.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | | | |
| | | | |
| | | | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 205000.00 | 103500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 205000.00 | 103500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 205000.00 | 103500.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Улаанхус сумын Согоог Хүүхдийн цэцэрлэг 2022 онд “хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж хичээл, сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах” зорилго дэвшүүлж байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

Хамран сургах тойргийнхоо цэцэрлэгт хамрагдаагүй хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалт зохион байгуулж, тэдний эцэг, эх, асран хамгаалагчид мэргэжлийн тусалцаа үзүүлнэ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэг нь Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын 2022 оны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг зохих журмын дагуу хөтөлж, анхан шатны баримт материалыг бүрдүүлж, бараа материалын тайланг гаргаж ажилласан байна.

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэг нь 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэг нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэг нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10.3 сая төгрөгөөр буюу 1.5 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 8,179.4 | 8,179.4 |
| Авлага | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 56,592.8 | 60,636.4 | 4,043.6 |
| Үндсэн хөрөнгө | 636,712.3 | 614,124.6 | -22,587.7 |
| **Нийт хөрөнгө** | **693,305.1** | **682,940.5** | **-10364.6** |
| Өр төлбөр | 3,707.4 | 6,373.3 | 2,665.9 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 689,597.7 | 676,567.1 | -13,030.6 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **693,305.1** | **682,940.1** | **-10,365.0** |

Мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 8.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь цалин, тогтмол зардал, норматив зардлын хэмнэлт байна.

Бараа материалын данс 4.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аж ахуйн материал, хүнсний материалын үлдэгдэл нэмэгдсэн нь нөлөөлсөн.Тайлант онд 78.5 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, хандиваар 0.4 сая төгрөгийн бараа материалыг хүлээн авч, үйл ажиллагаандаа 74.5 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө нь мөн 22.5 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 1.1 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч үндсэн хөрөнгөнд 23.6 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Тайлант онд 13.0 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 13.0 сая төгрөгөөр хасагдсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 611.9 сая, нийт зарлагыг 611.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол 2 удаа хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 413.3 сая төгрөгийг улсын төсвөөс, 51.3 сая төгрөгийг  орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр баталсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 413.3 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 51.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтээс 0,091 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 456.5 сая төгрөг буюу 98.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг  8.1 сая төгрөгөөр  дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2.  Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр арга,хэмжээ | Төлөвөлгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Эрүүл мэндийг дэмжих | 1,100 | 1,100 | - | 100% |
| 2 | Цэцэрлэгийн хүүхдийн хоол | 59,017 | 55,183 | 3,834 | 94% |
| 3 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 1,716 | 1,716 | - | 100% |
| 4 | Боловсролын байгууллагын багш | 1,100 | 1,100 | - | 100% |
| 5 | Боловсролын стандарт | 265,805 | 262,644 | 3,161 | 99% |
| 6 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 84,661 | 83,476 | 1,185 | 99% |
| 7 | Нийтлэг үйлчилгээ | 51,313 | 51,313.0 | - | 100% |
| | | **464,712** | **456,532** | **8,180** | **98.7%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэг нь дээд шатны төсвийн захирагчаас 0.1 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч багш нарын үнэлгээний бичиг хэргийн материалд зарцуулсан байна.

***3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн***

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэг 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор К.Еркегүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Улаанхус сумын Согоог хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 366.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.3 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа, ажил үйлчилгээний зардлыг нийт дүнгээр 8.1 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд зөрчил дутагдал гараагүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75% хугацаа хоцролтын хэрэгжилтийн хувь 100 % байна. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 14, шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*:
Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагын хэрэгжилтэд хийсэн аудитад дутуу оруулсан дараа бүрэн оруулж байхаар албан шаардлага өгөв.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар хүнсний материалын бүртгэл тайлагналтай холбоотой 23.1 сая төгрөгийн 2 албан шаардлага, шилэн данстай холбоотой 187.6 сая төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөн. Хэрэгжилтийг шалгахад: Өмнөх аудитаар хүнсний материалын бүртгэл тайлагналтай холбоотой 23.1 сая төгрөгийн 2 албан шаардлага, шилэн данстай холбоотой 187.6 сая төгрөгийн 1 зөвлөмжийг биелүүлсэн байна.

*Хүснэгт 4* Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 2 | 23100.0 | 2 | 23100.0 | 100% |
| Зөвлөмж | 1 | 187600.0 | 1 | 187600.0 | 100% |
| **Нийт дүн** | **3** | **210700.0** | **3** | **210700.0** | 100% |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 7.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 7.0 сая төгрөгийн албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдлөө.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар дараах 7.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэв.Үүнд:

1.Цэцэрлэг нь 2022 оны 18496 хүүхэд өдрөөр нийтдээ 52.8 сая төгрөгийн хүнсний материал буюу цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардалд дунджаар 2855 төгрөг зарцуулсан. Хүүхдийн нэг өдрийн хоолны зардлын нормтой харьцуулахад өдөрт 380 төгрөгөөр буюу жилийн дүнгээр 7.0 сая төгрөгөөр нормативыг хэтрүүлж зарцуулсан.

2. Шилэн дансанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 9.4 сая төгрөгийн 14 шийдвэрийг мэдээлээгүй, шилэн дансанд мэдээлсэн байдал 75 хувьтай байгаа зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал***

*1.1.Илрүүлэлт:*

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*1.2.Өгсөн зөвлөмж:*

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийн хангаж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж тушаалаар батлуулан, санхүү, бүртгэл, тайлагналын үйл ажиллагаандаа ашиглах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 05 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | 0 | 0 | | | 0 | 0 | 0 | 0 | | | | |
| **Дүн** | 0 | 0 | | | 0 | 0 | 0 | 0 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цэцэрлэгийн хүүхдийн хоолны нормыг хэтрүүлсэн | 1 | 7029.4 | | | 1 | 7029.4 | | | | | | |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 | | | | |
| **Дүн** | **2** | **7029.4** | | | **1** | **7029.4** | **1** | **0.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 8 шийдвэрийг мэдээлээгүй | 1 | 9468.9 | | | 1 | 9468.9 | | |
| **Дүн** | 1 | **9468.9** | | | 1 | **9468.9** | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | 0 | | | | | | | |
| **Нийт дүн** | 1 | **9468.9** | | | 1 | **9468.9** | | |